

Эрдэм шинжилгээний өгүүлэл  
УДК 821.512.36.0  
DOI 10.18101/3033-1310-2025-4-44-50

### Ж. Бямбын «Үнэний хорвоо» роман дахь хотын дүрслэл

© Пурэвсүрэнгийн Яндий

PhD, утга зохиолын тэнхимийн багш

Монгол улсын боловсролын их сургууль

Монгол Улс, 14191, Улаанбаатар хото, Сүхэ-Батор дүүрэг

yandii@msue.edu.mn

**Хураангуй.** Энэхүү өгүүлэлд Ж. Бямбын «Үнэний хорвоо» романд гарч буй хотын дүр, дүрслэл нь урбан уран зохиолын чухал бүрэлдэхүүн хэсэг тул романы үйл явдал өрнөх газар зүйн орон зай бус, харин соёл, нийгэм, сэтгэл зүйн олон талт утгыг шингээсэн бэлгэдэлт дүрслэл гэж үзэн судалсан болно. Судалгааны зорилго нь роман дахь хотын дүрслэлийг дүрүүдийн дотоод ертөнц, нийгмийн өөрчлөлт, соёлын үнэт зүйлстэй нягт уялдсан бэлгэдэлт орон зай болохыг жишээ баримтаар нотлон тодруулахад оршив.

Судалгааны явцад текстийн нарийвчилсан шинжилгээ, бэлгэдэлзүйн тайлал, орон зай, дүрийн харилцааг тодруулсны зэрэгцээ урбан уран зохиолын онолын чиглэлийн судалгааны бүтээлүүдийг ашиглан зохиолын хотын дүрслэлийн үр нөлөө, утга үүргийг тогтоолоо. Судалгаанд задлан шинжлэх (анализ), нэгтгэн дүгнэх (синтез), индукци дедукци, харьцуулах аргуудыг ашигласан болно. Үр дүнд нь Ж. Бямбын «Үнэний хорвоо» романд «ХОТ» хэмээх орчин нь ердөө газарзүйн байрлал биш бөгөөд хүний оюун санааны хямрал, нийгмийн ялзрал, мөн чанараа гээсэн орчин үеийн хүний бэлгэдэл болон дүрслэгдсэн байна.

**Түлхүүр үгс:** роман, хот, дүр, дүрслэл, сэтгэл зүй, байгаль, орон зай, үнэний хорвоо.

#### Для цитирования

Пурэвсүрэнгийн Яндий. Ж. Бямбын «Үнэний хорвоо» роман дахь хотын дүрслэл // Бурятский язык и литература в школе. 2025. № 4. С. 44–50.

#### Удиртгал

Орчин үеийн монгол уран зохиол нь хүний дотоод ертөнц, ёс суртахууны үнэт зүйлс, нийгмийн хандлагыг шүүмжлэлтэйгээр харуулсан бүтээлүүдээр баялаг. Тэдгээрийн нэгэн төлөөлөл нь Ж.Бямбын 1983 онд бичсэн "Үнэний хорвоо" роман юм. // ХХ зууны монгол зохиолчид. 1984. Дугаар 7-8 Тус бүтээл нь зохиолчийн "Эргэх хорвоогийн жам" хэмээх ерөнхий агуулгад зангидсан "Хорвоогийн өнгө"/1971/, "Энэрэлгүй хорвоо"/1981/ хэмээх цуврал романы гурав дахь нь бөгөөд ХХ зууны монголын уран зохиолын туурвил зүйн сэтгэлгээнд бодит нөлөө үзүүлж, тухайн үеийн утга зохиолын хөгжил дэвшил, үнэт зүйлд жинтэй хувь нэмэр оруулсан юм. // Монголын орчин үеийн уран зохиолын түүх-IV. 2014. Дугаар 217 Энэ үүднээс авч үзвэл зохиолч романдаа хүний үнэн, худлын зааг дээрх дотоод тэмцлийг сэтгэл зүйн гүн гүнзгий байдлаар дүрсэлснээрээ орчин үеийн монголын уран зохиолд онцгой байр суурь эзэлдэг байна. Романы талаар эрдэмтэн Ц.Хасбаатар "Хорвоогийн өнгийг олж харсангүй" хэмээх өгүүлэлдээ "Ж.Бямбаа эсрэг талынхаа баатруудын бүтэлгүй самуун явдалд хөтлөгдөн тэдний "гүн ухаан", хэрэг явдлыг уудлан үзүүлэх гэсээр байгаад улс төрийн ха-

*раагаа алдаж, шинэ амьдрал байгуулах лут их хөдөлгөөн өрнөж буй манай нийгмийн зургийг гутааж гуйвуулахад хүрсэн байна.* // ХХ зууны монгол зохиолчид. 1984. Дугаар 78 хэмээн шүүмжилжээ. Эрдэмтэн С.Байгалсайхан “Үнэний хорвоо” романы зарим дүрийн тухай” хэмээх шүүмждээ “Уг зохиолд хүнд суртал гаргах, өмч хөрөнгө үрэгдүүлэх, хуурч мэхлэх, эрх тушаал, нэр төр хөөцөлдөх, бялдуучлах, ууж согтуурах, хууль ёс, нийтийн хэв журам зөрчих зэрэг манай нийгмийн урагшлах хөдөлгөөнд саад болж буй ёс суртахууны доголдлыг шүүмжлэх замаар уншигчдад хүмүүжлийн ач холбогдолтой дүр бүтээхийг зорьжээ.” // Утгын чандмань. 2003. Дугаар 236 гэжээ. Эдгээр шүүмжүүдийг харвал, эрдэмтэн Ц.Хасбаатар романыг улс төрийн үзэл баримтлалаа алдаж, нийгмийн шинэ хөдөлгөөнд сөргөөр нөлөөлсөн хэмээн дүгнэсэн бол С.Байгалсайхан ёс суртахууны доголдлыг илрүүлж, хүмүүжлийн ач холбогдолтой дүр бүтээхийг зорьсон гэж үнэлжээ. Энэ мэт судлаачдын үнэлэлт дүгнэлтийг харгалзан, энэ удаа бид романы хотын дүрслэлийн зарим онцлогийг тодруулан авч үзлээ.

#### **Үндсэн хэсэг.**

Романд орчин үеийн хотын амьдрал болон хотжсон нийгмийн олон талт асуудлууд бодитоор дүрслэгддэг. Хотын гэр хороолол, барилга байгууламж, замын түгжрэл, хүн хоорондын харилцааны хямрал зэрэг дүрслэлийн элементүүдээр дамжуулан зохиолч орчин үеийн хотын амьдралын үнэн төрхийг харуулсан нь урбан уран зохиолд нийтлэг тохиолддог онцлог шинжүүдийн тусгал болж байна. Хотын уран зохиолын тухайд эрдэмтэн Д.Галбаатарын “Уран зохиолын нэвэрхий толь”-д *“Хот гэдэг нь хот, суурины тухай өгүүлсэн зохиол бус хот суурины хүн зоны иргэншил, аж төрөх ёс, маяг, зан суртахуун, амьдралын хэмнэлийг өөртөө гүн гүнзгий шингээсэн уран бүтээлийн ай хүрээг нийтэд нь илэрхийлдэг.* // Уран зохиол нэвтэрхий толь. 2012. Дугаар 471 гэсэн бол С.Энхбаяр Утга зохиолын ерөнхий онол туурвилзүй” номдоо *“Urban fiction буюу хотын уран зохиол нь их хотын нутаг дэвсгэр дээрх нийгэм, эдийн засаг, соёлын асуудлуудыг үнэн бодитой тусгасан шинжтэй хот, дүүрэг, гудамжны амьдралын дүр төрхийг илэрхийлсэн уран зохиолын нэг өвөрмөц төрөл.”* Утга зохиолын ерөнхий онол туурвил зүй. 2021. Дугаар 454 хэмээжээ. Энэ мэт эрдэмтэн судлаачдын онолын ойлголтод тулгуурлан Ж.Бямбын “Үнэний хорвоо” романы хотын дүрслэлийг дараах байдлаар авч үзлээ.

#### **1. Хотын хөгжил ба хүний дотоод сэтгэл зүйн зөрчил**

Романд Улаанбаатар, Улиастай хотыг хөгжил дэвшлийн төв болон дүрсэлсэн байдаг. Тухайлбал: *“Эдний хашаа толгойн энгэрт учир хавийн юмс нүднээ илхэн. Тэртээ өмнө этгээдэд их хотын барилга байшин цайран харагдаж, цаашилах тусмаа зуны хөнгөн цайвар униар дунд бүдгэрэн эрвийн сэрвийн торолзоно. Хашаанаас нь хоёр гудамжны өмнүүр Чингэлтэй уулын ам руу өгссөн засмал замаар гурван хаалгатай том улаан автобус хар утаа олгойдуулан зүтгэнэ. Зүүн талаар нь Сэлбийн голын эх рүү одсон замаар хааяа зуслангийн автобус явах нь үзэгдэнэ.* // Үнэний хорвоо. 1984. Дугаар 7-8 гэж хотын орчин нөхцлийг нийгэм-соёлын, экологийн олон давхар утгатай уран сайхны цогц ойлголт болгон харуулсан байна. Роман дахь өөр нэгэн хотын дүрслэл гэвэл *“Урангоо хотын өмнө талд ирж зогсоод: -Одоогоос хэдэн жилийн өмнө энэ их бургас чинь огт байгаагүй юм. Арваадхан жигтэйхэн аварга том хөгшин улиас байсан юм... Гэтэл насных нь тоо гүйцсэн ч юм уу, цөм унаж алга болоод тэртээ доод голын бэлчирт байсан бөөн бургас наашлан нүүсээр энэ гүүрнээс дээш гол өгсөж урга-*

саар байгаа юм даа гээд хойш эргэж бургасны дээгүүр дэрвэгэр цагаан дээвэр нь сарны гэрэлд цайран харагдаж байгаа монгол уран барилгын хэлбэртэй жижигхэн байшинг зааж: -Тэр байшингийн зүүхэн талд манай хаашаа байсан юм. // Үнэний хорвоо. 1984. Дугаар 120 хэмээн Улиастай хотын өөрчлөлт шинэчлэлийг харуулсан байна. Энэ мэт дүрслэлээс харахад зохиолч хотын хөгжлийг зөвхөн гадаад үзэмж, дэд бүтэц, барилга байгууламжаар хэмжих биш, харин тэнд оршин буй хүмүүсийн дурсамж, сэтгэл хөдлөл, амьдралын хэв маягаар дамжуулан илэрхийлсэн байна. Өөрөөр хэлбэл байгаль, орчин өөрчлөгдөх хэрээр хүний амьдрал ч өөрчлөгдөж, хуучны дурсамжууд бүдгэрч, шинэ ертөнцөд дасан зохицох шаардлага тулгардаг байна.

Үүнээс гадна хот шинэчлэгдэхийн хэрээр өнгө үзэмж нэмэгдсэн ч, иргэдийн сэтгэл зүйд хоосрол, төөрөгдөл үүсэж буйг зохиолч олон дүрүүдээр дамжуулан харуулсан. // Монголын орчин үеийн уран зохиолын түүхэн товчоо. 2022. Дугаар 258 Жишээлбэл: хотод ирж "шинэ амьдрал" эхлүүлэхээр зорьсон залуус, сэхээтнүүд анхны хүсэл мөрөөдлөө гэж, "утгагүй оршихуй"-тай нүүр тулгарах агаад тэдний хувьд хот гэдэг бол хүсэл тэмүүллийн орон зай бус, харин дотоод хямралын толь болон дүрслэгдсэн байна. Үүнийг тодруулбал романы гол баатрууд болох Мондоон (Барилгын яамны орлогч сайд), Түвшин (Трестийн дарга), Луузан (Засвар ангийн дарга), Манал (Ерөнхий инженер), Бөмбөг (Барилгын яамны газрын дарга) нар бүгд барилгын салбарын нэр нөлөөтэй албан тушаалтнууд бөгөөд зохиолд нийгмийн хөгжлийн илэрхийлэл мэтээр дүрслэгддэг. Гэвч эдгээр сэхээтнүүдийн дотоод ертөнц нь эзгүйрч, амьдралын утга учиргүйд автан, дотоод хоосролын орон зайд амьдараг. Өөрөөр хэлбэл тэдний ихэнх нь алдар нэр, эрх мэдлийн төлөө тэмцэж, хуурамч нийгмийн тогтолцоонд уусан орших авч, хааяа "миний сонгосон зам зөв үү, буруу юу?" хэмээн өөрөөсөө асуух эргэлзээ, итгэл найдварын үл мэдэг үл мөр үлдсэн байдаг. Энэ мэт дүрүүдийн дотоод тэмцэл нь зөвхөн хувь хүний асуудал бус, харин ч тухайн нийгмийн үнэ цэнийн системийн уналтыг илэрхийлж байна. Тиймээс хот бол эдгээр дүрүүдийн амжилтын тайз мэт харагдах ч үнэндээ ёс суртахууны доройтол, хүний мөн чанарын гажуудал шингэсэн орон зай болон хувирсныг зохиолч сэхээтнүүдийн дүрд шингээн шүүмжилж, хүн төвтэй, үнэт зүйлтэй нийгмийн эрэлд уншигчдыг хөтөлдөг.

Харин залуусын хувьд, хот бол хүсэл мөрөөдөл, эрх чөлөөний бэлгэдэл мэт харагддаг ч бодит байдал дээр тэд урагшлах ямар ч тодорхой зорилгогүй, төөрөгдсөн нэгэн болж хувирдаг. Үүнийг тодруулбал Урангоо анхнаасаа хотыг шинэ амьдралын эхлэл хэмээн харж, өөрийнхөөрөө амьдрахыг хүсч, эрх чөлөөг эрхэмлэдэг ч энэ хүсэл нь түүнийг тодорхой зорилгогүй, хийсвэр амьдрал руу хөтөлдөг. Өөрөөр хэлбэл хотын шуугиан, гял цал орчинд Урангоо өөрийгөө олоогүй, төөрөлдөж, ээдрээтэй амьдралын замд хөл тавьдаг байна. Тиймээс тэдний мөрөөдлийн ажил, амьдрал нь "хийсвэр" байдлаар үлдэж, амьдрал нь улам бүр зорилгогүй болон хувирсныг хотын дүрслэлээр харуулжээ. Энэ мэт зохиолч хотыг гадна талаас нь хөгжил цэцэглэлт ундарч буй мэт дүрсэлсэн ч дотор талаас нь хүний сэтгэл зүйн хямралыг харуулах хэрэгсэл болгож ашигласан байна. Цаашилбал барилга байгууламж, машин тэрэг, гудамж талбай зэрэг нь нэг талаар техник технологийн дэвшил, нөгөө талаар сэтгэлийн зөрчил болон хоосрол, утга учиргүй байдлын бэлгэдэл болжээ.

## 2. Хотжилт ба уламжлалт амьдралын хэв маягийн зөрчил

Зохиолд уламжлалт монгол ёс заншил, хүний мөн чанар хотын орчинд хэрхэн мөхөж, мартагдаж байгааг дүрслэх замаар соёлын зөрчлийг харуулдаг. Жишээ нь: "...Хүн гэдэг өөрийн гэсэн бодолтой амьдрах учиртай юм байна. Тэгж гэмээнэ урагш тэмүүлэн бүтээхийн хүслээр дүүрэн явдаг байх. Зүгээр л нэг амьдралын гольдрол даган аар саархан юмаар хөөцөлдөн голд хаягдсан зомгол шиг урсаж байвал нэг л мэдэхэд хорвоо өнгөрч хувь заяа нь гунигтайгаар дуусдаг бололтой. Тэгэхлээр аав шиг явах хэрэгтэй юм байна даа" гэж Урангоо бодож байлаа." // Үнэний хорвоо. 1984. Дугаар 140] хэмээснээс "аав шиг явах" гэсэн нь уламжлалаа хадгалах, өвлөх ёстой гэсэн үзлийн илэрхийлэл болжээ. Өөрөөр хэлбэл хотын амьдралыг даган хөөцөлдөж, амьдралаа зорилоггүй, утга учиргүй өнгөрөөх нь хүний мөн чанар, утга учир, уламжлалаа гээх, мартах эрсдэлтэй болохыг сануулжээ. Түүнчлэн хотод амьдарч буй зохиолын дүрүүд уламжлалт үнэт зүйлсээ гээж, материаллаг шунал, албан тушаал, нэр хүндийн төлөө амьдарч буй нь ёс суртахууны доройтлын илэрхийлэл болсон байна. Жишээ нь: "Цагаан саан хөшиг, том том хээтэй хул шаргал торгон хөшигийг тус тус ярсан гурван том цонхоор туссан нарны гэрэлд өрөө даанч саруулхан. Цонхон талд буй урт ширээг тойруулан зөөлөвчтэй сандал эгнүүлжээ. Эсрэг талын ханын дагууд олон шургуулга, шил толь нь гялалзсан өндөр хүрэн шүүгээ тавьжээ. Өрөөнд "Алтанбулаг" хэмээх солонгорсон алаг эрэн хивс... Олон болор хэлхэн унжуулсан чийдэнгийн гурван алтан бүрхүүл талстан гялалзана." // Үнэний хорвоо. 1984. Дугаар 48-50 гэж Мондооны гэрийн баян чинээлэг, хангалуун байдлыг нүдэнд харагдахуйц тоочин дүрсэлж, түүний нийгмийн байр суурь, гоо зүйн хандлага, сэтгэлзүйн байдал зэргийг давхар илтгэжээ. Энэ мэт дотоод орчны зохион байгуулалт, тавилга, гэрэлтүүлэг, эд хэрэглэл зэргээс монгол уламжлалт ахуйн зарим бэлгэдэл, хэрэглээ, зохион байгуулалтын хэв маяг орчин үеийн орон сууцны амьдралтай уялдан хөгжиж, шинэчлэгдсэнийг харж болох төдийгүй уламжлалт монгол ахуй амьдралаасаа холдсоныг ч харах боломжтой байна.

Өөр нэг жишээ гэвэл "Танхим тун ч бүгчим халуун байлаа. Хуралдагсдын дийлэнх нь судалтай судалгүй, эрэн мяраан том жижиг алчуураар, хааяа нэг хүн эвхээстэй сонин мэтээр хөлсөө сэвж, зарим нь өөр хоорондоо шивэр авир гэлцэх нь ихэд алжааж залхсан байдалтай. Цонх нэвтлэн танхимын нөгөө хананд туссан нарны туяа огшин огшоор хүмүүсийн нүүр царайг ташуу гийгүүлэн тааз руу авиран гарч тэгснээ богиноосоор цонхны дээд ирмэгээс зууран салж ядах мэт байснаа мултрав. Хүмүүсийн зарим нь наран шингэн улааран байгаа тэнгэрийн хаяа руу цонхоор ширтэх нь гадаа гарахын хүслэн болж буй бололтой." // Үнэний хорвоо. 1984. Дугаар 137] хэмээжээ. Энд уламжлалт монгол хүний үнэт зүйл ба хотын орчин, шинэ нийгмийн бодит байдал хоорондын зөрчил хийгээд тэр дундаа хүний сэтгэлгээ, орчин нөхцөл, нийгмийн уур амьсгалын хөндийрөл зэргийг уран яруу дүрсэлжээ. Үүнийг тодруулбал "Танхим тун ч бүгчим халуун байлаа..." гэсэн нь шууд утгаараа "зуны халуун" мэт боловч, сэтгэл гутралтай, хүнд уур амьсгалтай, бодолгүй массын дүр төрхийг төлөөлж байна. Харин орчин нөхцлийн хувьд хот газрын шигүү бөгчим амьсгалах зайгүй дүр төрхийг дүрсэлжээ. Үүнээс гадна "Хуралдагсдын дийлэнх нь судалтай судалгүй, эрэн мяраан алчуураар... хөлсөө сэвж..." гэснээр хүмүүсийн амьдралын өөр өнгө төрх, өөр хоорондоо зохицолгүй байдлыг илэрхийлэхийн зэрэгцээ хүн бүрийн бодлогогүй, зохион байгуулалтгүй байдлыг дүрсэлсэн байна. Алчуураар хөлсөө

сэвэх нь түр зуурын арга бөгөөд амьдралд идэвхгүй, өөрийгөө зовоогоод ч яах учраа олохгүй байгаа хүний дүрийг харуулжээ. “Нарны гэрэл”, “огшин огшиж”, “ташуу гийгүүлж”, “салж ядан байснаа мултрах” зэрэг цаг хугацаа байгалийн дүрслэлээр уламжлалт үнэт зүйлс, байгалийн жам ёс, амьдралын утга учир танхим доторх хиймэл орчноос “тасрах” буюу холдох шиг болж буйг бэлгэдэлтэйгээр дүрсэлсэн нь суурин болон суурин бусын ялгааг тод томруун харуулсан байна. Тэгэхээр нар бол жинхэнэ амьдралын утга, гадаах байгаль бол эрх чөлөөт, байгалийн эрүүл орчин юм. Харин танхим бол хүний хиймэл, соёлын шахалттай хотын амьдрал болохыг дүрсэлжээ. Эндээс харахад хотын орчин бол хүний мөн чанарыг боомилж байгаа бол бодит байгаль, гэрэл нь амьдралын үнэн утгыг илэрхийлж байна. Нөгөө талаар уламжлал, жам ёсны амьдралын хэмнэл орчин үеийн соёлд хавчигдаж буйг сэтгэл зүй, байгаль, орон зайн дүрслэлээр уран яруу илэрхийлжээ. Үүнээс гадна хотын тухай өөр нэгэн дүрслэлд “Харанхуй болж гудамжны гэрэл асчээ. Үдшийн хөдөлгөөн татраагүй учир автобус, том жижиг тэрэг гэрлээ гялбалзуулан өөд сөргөө давхилдан гудамж дүүрэн чимээ нижигнэж, явган зорчигчдын хөлдүү баригшин, дагтарсан цасан дээр тов тов, чихар чихар алхах нь сонсогдоно.” // Үнэний хорвоо. 1984. Дугаар 143] гэснээс хотын орчны уур амьсгал, хүний амьдралын хэмнэл хэрхэн өөрчлөгдөж, уламжлалт тайван байдал, байгалийн жам ёсны амьдралаас холдож байгааг илэрхийлсэн байна. “Харанхуй болж гудамжны гэрэл асчээ.” гэснээс хотын орчинд байгалийн хэмнэл бус хүний бүтээсэн орчин давамгайлж байгааг илтгээд, Автобус, том жижиг тэрэг гэрлээ гялбалзуулан...” гэж хотын амьдралын түймэр мэт хэмнэл, тасралтгүй хөдөлгөөн, стресс дүүрэн орчны дүрээр сэтгэл цочроосон, нүд эрээлжлүүлсэн, амгалан биш байдлыг илтгэж байна. Мөн “Гудамж дүүрэн чимээ нижигнэж...” гэснээс уламжлалт амьдралд байх амгалан тайван уур амьсгал үгүй болж, оронд нь шуугиан, техник, хөл хөдөлгөөн давамгайлж буй дүр зураг тодрох бөгөөд энэ нь хүний дотоод сэтгэл ч мөн адил чимээтэй, тайван бус болж буйг бэлгэджээ. Эндээс харахад зохиолч:

1. Уламжлалт амьдралын дулаан, зөөлөн уур амьсгалаас хөндийрснийг
  2. Хүн ба байгаль хоёрын холбоо тасарсныг
  3. Хотын их дуу чимээ, хүйтэн хөдөлгөөнтэй амьдрал болохыг
  4. Хүмүүс уламжлалт амьдралын дулаан, зөөлөн уур амьсгалаас хөндийрснийг
  5. Соёлын зөрчил болон хүний дотоод мөн чанар мөхлийн ирмэгт хүрснийг
- романд хотын дүрслэлээр илэрхийлсэн байна. Эндээс харахад романы өгүүлэмж бүхэлдээ хотын дүрслэлтэй сүлжилдсэн нь “Үнэний хорвоо” гэгчид орших хот бол үнэн ба худал, ёс суртахуун ба завхралын зааг болж, нийгмийн харилцаа, оршихуйн сэтгэл зүйг илэрхийлэх бэлгэдэлт орон зай болон хувирчээ.

#### Дүгнэлт

1. Романд “ХОТ” хэмээх орчин нь ердөө газар зүйн байрлал биш бөгөөд хүний оюун санааны хямрал, нийгмийн ялзрал, мөн чанараа гээсэн орчин үеийн хүний бэлгэдэл болон дүрслэгдсэн байна. Энэ үүднээс авч үзвэл зохиолч хотын дүрслэлээр дамжуулан нийгэм дэх ёс суртахууны хямрал, уламжлалын доройтол, хүний дотоод үнэ цэнийн уналтыг шүүмжилжээ.
2. Зохиолын турш хотыг зохиолч хүйтэн, сэтгэлгүй, механик шинжтэй орчин хэмээн дүрсэлдэг. Хотын гудамж, барилга, машин тэрэг зэрэг нь гаднаа

өнгөлөг боловч хүний сэтгэлийн гүнд хоосрол, төөрөгдөл, ганцаардал гэгчийг бий болгож буйг харуулсан байна.

3. Зохиолын дүрүүдийн сэтгэл зүйд анзаарагдах зөрчил нь хотын орчинд илүү хурц мэдрэгддэг. Энэ нь гадаад ертөнц гэрэл гэгээтэй мэт боловч хүний сэтгэл дотор уй гашуу, ганцаардал, айдас ноёлдог. Өөрөөр хэлбэл романы хотын уур амьсгал нь дүрийн сэтгэл зүйн энэ байдалтай нарийн уялдан дүрслэгдсэн бөгөөд зохиолч энэ байдлыг уянгын өнгө аясаар бичсэн нь уншигчийг зөвхөн нийгмийн биш, өөрийн дотоод ертөнцөө ч мөн эргэцүүлэхэд нөлөөлсөн байна.

### Ном зүй

1. Галбаатар Д. Уран зохиол: онол, түүх, шүүмжлэл. Улаанбаатар, 2012. 594 тал
2. Галбаатар Д. Уран зохиол нэвтэрхий толь. Улаанбаатар, 2012. 471 тал
3. Бямба Ж. Үнэний хорвоо. Улаанбаатар, 1984. 7–8 тал, 120 тал, 140 тал, 48–50 тал, 137 тал, 143 тал.
4. Бямба Ж. ХХ зууны монгол зохиолчид / оршил өгүүлэл ба тайлбарын зохиогч Б. Мөнхбаяр. Улаанбаатар, 2013. 7–8 тал, 78 тал.
5. Байгалсайхан С. Утгын чандмань. Улаанбаатар, 2003. 236 тал.
6. Монголын орчин үеийн уран зохиолын түүх-IV. Улаанбаатар, 2014. 217 тал.
7. Энхбаяр С. Утга зохиолын ерөнхий онол туурвил зүй. Улаанбаатар, 2021. 454 тал.
8. Энхбаяр С. Утга зохиолын онол. Улаанбаатар, 2008. 200 тал.
9. Яндий П. Монголын орчин үеийн уран зохиолын түүхэн товчоо. Улаанбаатар, 2022. 258 тал.

Нийтлэлийг редакторууд 2025 оны 11-р сарын 20-нд хүлээн авсан; 2025 оны 11-р сарын 27-нд хянасны дараа батлагдсан; 2025 оны 12-р сарын 1-нд хэвлүүлэхээр хүлээн авсан.

## The Image of the City and the Urban Environment in J. Byamba's Novel World of Truth

*Purevsuren Yandii*

Ph.D., A/Prof.

Mongolian National University of Education

Sukhe-Batora St., 14191 Ulaanbaatar, Mongolia

yandii@msue.edu.mn

*Abstract.* The article studies the urban image and depiction of the city in J. Byamba's novel *World of Truth*. The urban image and the city's portrayal constitute an important component of urban literature and are studied here not as a geographical setting where the novel's events unfold, but as a symbolic representation that embodies diverse cultural, social, and psychological meanings.

The purpose of the study was to demonstrate, through concrete examples, that the depiction of the urban environment in the novel functions as a symbolic space closely tied to the characters' inner worlds, social change, and cultural values.

As part of the study, in addition to close textual analysis, symbolic interpretation, and clarification of the relationship between space and character, theoretical works in urban literary studies were used to determine the effect and significance of the novel's urban imagery.

The methods used include analysis, synthesis, induction–deduction, and comparison. The study concludes that in J. Byamba's *World of Truth*, the environment referred to as the *CITY*

---

is not merely a geographic location but a symbol of humanity's spiritual crisis, social decay, and the modern individual who has lost their essence.

*Keywords:* novel, city, character, imagery, psychology, nature, space, *World of Truth*.

*For citation*

Purevsuren Yandii. The Image of the City and the Urban Environment in J. Byamba's Novel *World of Truth*. *Buryat Language and Literature in School*. 2025; 4: 44–50 (In Mong.)

*The article was submitted 20.11.2025; approved after reviewing 27.11.2025; accepted for publication 01.12.2025.*